

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Л.Баянмөнх
Утас: 99997540
Цахим хаяг: bayanmunkhamina@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

_____ дот б.од.дд № _____ 78

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Э.НАСАНДЭЛГЭР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад үйл ажиллагааны орлого өмнөх оноос 142.7 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 177.8 сая төгрөгөөр буурч, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих санхүүжилт 37.4 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлж байна. Үйл ажиллагааны зардал 386.2 сая төгрөгөөр өссөний 71.4 хувийг цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4826050261

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 46 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Эрдэнэдалай сумын засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 96.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,047,326.32	33,348,730.33
312	Банканд байгаа бэлэн мөнгө	14,047,326.32	33,348,730.33
3121	Төгрөг	14,047,326.32	33,348,730.33
31211	Төрийн сангийн харилцах	13,095,466.32	33,348,730.33
31218	Ахмадын сангийн харилцах	951,860.00	-
33	АВЛАГА	272,211,311.40	128,218,076.68
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	272,211,311.40	126,000,783.07
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	951,860.00
335	Бусад авлага	-	487,523.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	487,523.00
35	БАРАА МАТЕРИАЛ	200,592,618.40	225,726,555.79
351	Түүхий эд материал	106,853,303.16	105,452,672.35
35110	Тусгай зориулалттай материал	67,787,948.21	70,603,708.08
35130	Эм боох материал	39,065,354.95	34,848,964.27
354	Хангамжийн материал	84,889,315.24	120,273,883.44
35410	Бичиг хэргийн материал	3,538,250.00	7,251,490.00
35420	Аж ахуйн материал	78,034,022.74	103,010,557.74
35450	Барилгын засварын материал	535,000.00	535,000.00
35460	Хүнсний материал	2,782,042.50	9,476,835.70
35600	Мал амьтад	8,850,000.00	-
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	486,851,256.12	387,293,362.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,866,304,870.59	2,771,338,919.35
392	Биет хөрөнгө	2,847,020,870.59	2,752,054,919.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,676,920,670.00	2,676,920,670.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(333,040,607.86)	(401,550,692.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	216,472,000.00	216,472,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(51,764,350.16)	(77,894,883.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	359,027,481.36	457,547,668.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(138,200,612.14)	(209,522,415.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160,585,725.40	163,700,825.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,182,068.16)	(76,574,994.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,412,254.62	7,412,254.62
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,209,622.47)	(4,455,512.99)
393	Биет бус хөрөнгө	19,284,000.00	19,284,000.00
39301	Программ хангамж	860,000.00	860,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(860,000.00)	(860,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,284,000.00	19,284,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,866,304,870.59	2,771,338,919.35
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,353,056,126.71	3,158,632,282.15
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,506,736.95	21,029,427.56
413	Өглөг	4,506,736.95	21,029,427.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	89,367.82	2,460,485.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,417,369.13	18,490,546.52
4136	Бусад өглөг	-	78,395.73
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	78,395.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,506,736.95	21,029,427.56
51	Засгийн газрын хувь оролцоо	3,348,649,389.76	3,137,602,854.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	387,031,873.10	387,031,873.10
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	387,031,873.10	387,031,873.10
512	Хуримтлагдсан үр дүн	2,771,916,631.40	2,560,870,096.23
51210	Өмнөх үеийн үр дүн	2,445,680,480.90	2,771,916,631.40
51220	Тайлант үеийн үр дүн	326,236,150.50	(211,046,535.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	189,700,885.26	189,700,885.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,348,649,389.76	3,137,602,854.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,353,156,126.71	3,158,632,282.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,572,991,544.30	1,628,119,908.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,209,900.00	147,921,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,209,900.00	147,921,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,442,781,644.30	1,480,198,208.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,442,781,644.30	1,480,198,208.50
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	347,014,167.77	149,097,148.42
120	Нийтлэг татварын бус орлого	347,014,167.77	149,097,148.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,949,770.50	37,097,605.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,949,770.50	37,097,605.80
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	255,308,974.96	77,460,986.82
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	34,755,422.31	34,538,555.80
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,920,005,712.07	1,777,217,056.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,593,208,228.17	1,979,413,592.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,539,750,969.83	1,941,640,272.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	861,975,508.47	1,138,013,045.88
210101	Үндсэн цалин	530,802,119.02	725,894,019.70
210102	Нэмэгдэл	254,201,869.45	331,450,686.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,620,000.00	26,194,700.00
210104	Урамшуулал	63,351,520.00	54,473,639.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,143,352.09	140,225,833.95
210201	Тэтгэврийн даатгал	73,954,565.24	95,437,309.28
210202	Тэтгэмжийн даатгал	8,700,449.42	11,356,924.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,616,852.98	5,897,124.23
210204	Ажилгүйдлийн даатгал	4,179,740.92	5,506,894.89
210205	Эрүүл мэндийн даатгал	16,691,743.53	22,027,580.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	116,343,936.66	123,849,420.75
210301	Гэрэл, цахилгаан	10,275,511.66	17,986,195.75
210302	Түлш, халаалт	100,068,425.00	99,863,225.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,795,490.09	66,789,340.00
210401	Бичиг хэрэг	4,212,700.00	3,737,660.00
210402	Тээвэр, шатахуун	39,773,380.50	52,187,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,858,900.00	3,841,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,169,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,781,009.59	7,023,140.00
2105	Нормативт зардал	136,100,850.32	176,829,369.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,704,699.32	149,621,684.28
210502	Хоол, хүнс	22,396,151.00	21,307,684.79
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	5,900,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,354,000.00	29,695,560.00
210604	Урсгал засвар	18,354,000.00	29,695,560.00
2107	Томилолт, зочны зардал	12,908,000.00	16,525,000.00
210702	Дотоод албан томилолт	12,908,000.00	16,525,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,692,922.00	25,202,894.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,640,000.00	20,719,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	616,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,082.00	347,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	336,840.00	336,840.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	203,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,436,910.20	224,509,809.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,099,325.11	6,463,571.13
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	170,337,585.09	218,046,238.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,457,258.34	37,773,319.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,946,000.00	33,552,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,946,000.00	33,552,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,511,258.34	4,221,319.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,511,258.34	4,221,319.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,593,208,228.17	1,979,413,592.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	326,797,483.90	(202,196,535.17)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	561,333.40	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	8,850,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	561,333.40	8,850,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(561,333.40)	(8,850,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	326,236,150.50	(211,046,535.17)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,325,390,854.90	1,774,230,436.83
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,209,900.00	147,921,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,209,900.00	147,921,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,195,180,954.90	1,626,308,736.83
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,195,180,954.90	1,626,308,736.83
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	56,949,770.50	37,097,605.80
120	Нийтлэг татварын бус орлого	56,949,770.50	37,097,605.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,949,770.50	37,097,605.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,949,770.50	37,097,605.80
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,382,340,625.40	1,811,328,042.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,387,845,040.66	1,759,657,338.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,334,387,782.32	1,720,932,159.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,416,490.07	1,136,675,641.14
210101	Үндсэн цалин	531,243,100.62	724,556,614.96
210102	Нэмэгдэл	254,201,869.45	331,450,686.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,620,000.00	26,194,700.00
210104	Урамшуулал	63,351,520.00	54,473,639.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,143,352.09	140,279,159.08
210201	Тэтгэврийн даатгал	73,954,565.24	95,490,634.41
210202	Тэтгэмжийн даатгал	8,700,449.42	11,356,924.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,616,852.98	5,897,124.23
210204	Ажилгүйдлийн даатгал	4,179,740.92	5,506,894.89
210205	Эрүүл мэндийн даатгал	16,691,743.53	22,027,580.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,548,641.66	124,173,420.75
210301	Гэрэл, цахилгаан	10,275,511.66	17,986,195.75
210302	Түлш, халаалт	107,273,130.00	100,187,225.00
210303	Цэвэр, бохир ус	6,000,000.00	6,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66,911,230.50	79,364,870.00
210401	Бичиг хэрэг	4,609,750.00	5,904,100.00
210402	Тээвэр, шатахуун	43,713,310.50	52,187,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,858,900.00	3,841,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,169,500.00	-

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,559,770.00	17,432,230.00
2105	Нормативт зардал	118,989,646.00	155,300,064.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,951,662.00	128,267,376.40
210502	Хоол, хүнс	22,637,984.00	20,637,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	6,395,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,599,000.00	37,296,810.00
210604	Урсгал засвар	23,599,000.00	37,296,810.00
2107	Томилолт, зочны зардал	12,908,000.00	16,525,000.00
210702	Дотоод албан томилолт	12,908,000.00	16,525,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,664,922.00	25,120,894.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,160,000.00	20,637,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	616,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	268,082.00	347,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Газрын төлбөр	336,840.00	336,840.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	452,000.00	203,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,206,500.00	6,196,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,206,500.00	6,196,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,457,258.34	38,725,179.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,946,000.00	33,552,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,946,000.00	33,552,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,511,258.34	4,221,319.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,511,258.34	4,221,319.25
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	951,860.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	951,860.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	<u>1,387,845,040.66</u>	<u>1,759,657,338.62</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(5,504,415.26)</u>	<u>51,670,704.01</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,625,000.00	32,369,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,625,000.00	32,369,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,625,000.00	32,369,300.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	17,625,000.00	32,369,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(17,625,000.00)</u>	<u>(32,369,300.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(23,129,415.26)	19,301,404.01
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,332,741.58	14,047,326.32
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,047,326.32	33,348,730.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1 үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,445,609,657.79	3,022,342,416.15

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,823.11	70,823.11
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,445,680,480.90	3,022,413,239.26
Тайлант үеийн үр дүн	-	-	326,236,150.50	326,236,150.50
2016 оны 12-р сарын 31 үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,771,916,631.40	3,348,649,389.76
2017 оны 1-р сарын 1 үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,771,916,631.40	3,348,649,389.76
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,771,916,631.40	3,348,649,389.76
Тайлант үеийн үр дүн	-	-	(211,046,535.17)	(211,046,535.17)
2017 оны 12-р сарын 31 үлдэгдэл	387,031,873.10	189,700,885.26	2,560,870,096.23	3,137,602,854.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,015,422,700.00	1,786,853,459.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,015,422,700.00	1,786,853,459.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,976,870,700.00	1,753,301,459.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,281,450,600.00	1,136,675,641.14
210101	Үндсэн цалин	858,685,800.00	724,556,614.96
210102	Нэмэгдэл	288,394,800.00	331,450,686.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,000,000.00	26,194,700.00
210104	Урамшуулал	78,370,000.00	54,473,639.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	167,001,700.00	140,279,159.08
210201	Тэтгэврийн даатгал	110,561,700.00	95,490,634.41
210202	Тэтгэмжийн даатгал	13,610,100.00	11,356,924.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,804,900.00	5,897,124.23
210204	Ажилгүйдлийн даатгал	6,805,000.00	5,506,894.89
210205	Эрүүл мэндийн даатгал	29,220,000.00	22,027,580.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	127,921,700.00	124,173,420.75
210301	Гэрэл цахилгаан	17,986,200.00	17,986,195.75
210302	Түлш халаалт	103,935,500.00	100,187,225.00
210303	Цэвэр бохир ус	6,000,000.00	6,000,000
2104	Хангамж, бараа материалын зардал	87,388,100.00	80,919,870.00
210401	Бичиг хэрэг	6,003,900.00	5,904,100.00
210402	Тээвэр, шатахуун	58,226,900.00	52,187,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,157,300.00	3,841,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,000,000.00	18,987,230.00
2105	Нормативт зардал	197,216,800.00	166,524,264.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,481,800.00	139,491,576.40
210502	Хоол, хүнс	28,340,000.00	20,637,688.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,395,000.00	6,395,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,894,600.00	56,886,910.00
210601	Багаж, техник хэрэгсэл	19,590,100.00	19,590,100.00
210604	Урсгал засвар	38,304,500.00	37,296,810.00
2107	Томилолт, зочны зардал	18,710,000.00	16,525,000.00
210702	Дотоод албан томилолт	18,710,000.00	16,525,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	29,037,500.00	25,120,894.00

210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	23,696,800.00	20,637,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,419,200.00	2,419,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	978,500.00	616,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо	500,000.00	347,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	300,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	500,000.00	336,840.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	203,000.00	203,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,249,700.00	6,196,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,249,700.00	6,196,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,552,000.00	33,552,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	33,552,000.00	33,552,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,015,422,700.00	1,807,106,723.38
122001	Хандив тусламж	1,817,412,800.00	1,626,308,736.83
122005	Орон нутгийн санхүүжилт	147,921,700.00	143,700,380.75
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого	36,992,700.00	37,097,605.80
10001	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	13,095,500.00	
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		13,095,466.32
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл		13,095,466.32
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,348,730.33
12100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	-	33,348,730.33

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,659.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 24,628.2 мянган төгрөгийн 2 зөвлөмж, 12,031.4 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

3.1 Албан шаардлага

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 12,031.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын нөөцийг бүрдүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д (*нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх*) заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна;

Шийдвэрлэсэн нь:

Хэмнэлтийн горим баримталж, төсвийн хөрөнгийг зүй зохистой хэмнэлттэй зарцуулах албан шаардлагыг хүргүүллээ.

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Үр дүнгийн тайланд 7,076.8 мянган төгрөгийн нормативт зардлыг хангамжийн бараа материалын зардалд бүлэг хооронд нь гүйлгэн тайлагнасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д (*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан*

шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах) заасныг, мөн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Үр дүнгийн тайланд зардлын ангиллын дагуу үнэн зөв бүртгэх тухай зөвлөмж өгсөн. *(Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хуулийн хугацаанд ирүүлж, хэрэгжилтийг 2026.06.01-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлэх)*

Илрүүлэлт 2

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Тайлант хугацаанд аж ахуйн материал, тусгай зориулалтын материалын дансанд 13 нэрийн 25 ш 17,551.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д *(Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах)* заасныг, мөн үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв бүртгэж, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх асуудлыг холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлэх тухай зөвлөмж өгсөн. *(Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хуулийн хугацаанд ирүүлж, хэрэгжилтийг 2026.06.01-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлэх)*

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудиттай холбоотой 12,031.4 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь авч үзсэн. Дүгнэлтэд нөлөөлөх аудитаар 24,608.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс завсрын аудитын 7,076.8 мянган төгрөгийн зөрчлийг жилийн эцсийн аудитаар хэрэгжсэн байна. Санхүүгийн аудитын 17,551.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд нормативт зардлыг хангамжийн бараа материалын зардалд бүлэг хооронд нь гүйлгэн тайлагнасан.	1	7,076.8					1	7,076.8		
Тайлант хугацаанд аж ахуйн материал, тусгай зориулалтын материалын дансанд 13 нэрийн 25 ш үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан.	1	17,551.3					1	17,551.3		
Дүн	3	24,608.1			1	12,031.5	2	24,608.1	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тусгай зориулалтын материал дансанд 4 төрлийн 1390 ш амны хаалт, халат, комбинзон, нүдний шил, нүүрний хаалт зэрэг нэг удаагийн хамгаалах хэрэглэл нөөцөөр хадгалагдаж байна.	1	12,031.5			1	12,031.5				
Дүн	1	12,031.5			1	12,031.5				